

ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Г.ЧУЛУУНБААТАРЫН ХЭЛСЭН ҮГ

Эрхэмсэг ноён Элчин сайд аа!

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид аа!

Хатагтай ноёд оо!

Энэ онд манай хоёр улсын харилцааны хөгжилд баларшгүй ул мөрөө үлдээсэн «БНМАУ болон БНХАУ-ын хооронд Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулагдсаны түүхт 70 жилийн ой тохиож байгаа билээ. Өнөөдөр та бид энэ түүхэн үйл явдлын үнэ цэн, ач холбогдлын талаар шүүн ярилцахаар энэ танхимд хуран цуглараад байна. Энэ сайхан хурлыг санаачлан зохион байгуулсан Олон улс судлалын хүрээлэн, дэмжиж хамтран ажилласан БНХАУ-ын Элчин сайдын яам, мөн хамтран дэмжиж ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын эрдэмтэн судлаачдаа Шинжлэх ухааны академийн нэрийн өмнөөс болон нийт эрдэмтдийнхээ өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэхүү түүхэн хэлэлцээр нь түүхийн үүднээс бол нүүдэлчдийн байгуулсан анхны төрт улс Хүннү эзэнт гүрний хийгээд эртний Хятадын Хан улсын хооронд хоёр улс тус тусын улсыг хүлээн зөвшөөрч, хилийн заагаа тогтоон, тэгш эрхтэй харилцаа тогтоож байсан эрх үүргийн гэрээнээс хойш түүхэндээ хоёр дахь удаагаа ийнхүү хоёр улс олон улсын дипломат ёсны түвшинд байгуулсан хэлэлцээр бөгөөд хоёр улс бие биеэ тусгаар улс хэмээн хүлээн зөвшөөрсөн үед тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд харилцан ашигтай, тэгш эрхтэй байх зарчмын үндсэн дээр байгуулсан, хоёр улсын засгийн газар хоорондын найрамдал, хамтын ажиллагааны анхны түүхэн баримт бичиг байсан юм. Өнгөрсөн 70 жилийн хугацаанд энэхүү түүхэн хэлэлцээр нь БНМАУ-ын бүтээн байгуулалт, эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлсний зэрэгцээ БНХАУ-ын хувьд ч олон улсад өөрийн байр суурийг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагаа, нөхөрлөлийг өргөжүүлэн тэлэх, дэлхийн бүх улстай найрамдалт харилцаагаа эрхэмлэн хөгжүүлэх гадаад бодлогынх нь нэгэн чухал үзүүлэлт болсоор ирсэн билээ. Энэхүү түүхэн хэлэлцээрийг эрдэмтэн судлаачид олон талаас нь үнэлж дүгнэсээр ирсэн, өнөөдрийн хурал ч энэ үнэлгээ дүгнэлтэд шинэ чухал алхам болно гэдгийг хэлэхэд эргэлзэхгүй байна. Юуны өмнө энэхүү хэлэлцээр нь геополитикийн, геостратегийн, бүс нутгийн хамтын ажиллагааны нэг чухал чиглэл болсоор ирснийг өнөөдөр хөндөж ярилцана гэдэгт эргэлзэхгүй байна. Мөн хоёр орны улс төр, дипломат харилцааны ерөнхий чиг шугам, ноён нуруу болж өнгөрсөн 70 жилд хамтын ажиллагааны гол удирдамж, хүрээг тодорхойлж ирснийг бас нарийвчлан ярилцах байх гэж бодож байна. Худалдаа, эдийн засгийн харилцааны өргөн хүрээг

хамарсан, чухал асуудлууд ч өнөөдрийн хурлаар хөндөгдөж, ярилцах болов уу гэж найдаж байгаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа энэ хүрээний ололт амжилт, тулгамдаж байгаа асуудлуудыг эрдэмтэн судлаачид та бүхэн тал бүрээс нь хөндөж ярилцах болов уу гэж итгэж байна. Мөн хоёр улсын найрамдал хамтын ажиллагаанд шийдвэрлэх үүрэгтэй байдаг хувийн хэвшлийн байгууллагууд, иргэд хоорондын харилцааны тулгамдсан асуудлууд, туршлага сургамжийг ч тал бүрээс нь шүүн хэлэлцэнэ гэдэгт бас эргэлзэхгүй байна. Энэ хуралд илтгэл тавин хэлэлцүүлж байгаа эрдэмтэн судлаачид маань миний дээр хөндөж ярьсан зарим чиглэлүүдийн зэрэгцээ өөр өөрийн судалгааны арвин баян туршлагаас хуваалцаж, судалгааныхаа явцад олж хуримтлуулсан шинэ мэдлэг, мэдээлэл, илрүүлж шинжилсэн түүхэн сурвалж бичгүүд, үйл явдлуудыг дүгнэн цэгнэж ярилцах, энэ үндсэн дээрээ хоёр орны найрамдал хамтын ажиллагааны цаашдын чиглэлд шинэ санаа оноо, шинэ боломж гарцыг дэвшүүлэн ярилцсан бүтээлч хэлэлцүүлэг болно гэдэгт миний бие эргэлзэхгүй байна. Ингээд Эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж байгаа бүх хүмүүст дахин талархал илэрхийлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье. Та бүхэнд баярлалаа.